

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/95-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2023 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Х.Алтанчимэг Утас: 90060105 Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Э.БОЛОРЦЭЦЭГ
ТАНАА

2023.02.13 № 28
танай _____ -ны № _____ -т

Г Хязгаарлалттай дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Сумын ЗДТГ-ын гэрээт ажилтан хог тээвэрлэх автомашины жолоочийг өндөр насны тэтгэвэрт гаргахад нь төсвөөс 36 сарын цалинтай тэнцэх 7,202.8 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон;
2. Хог хаягдлыг зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал зардлын дансанд хог тээврийн автомашины жолоочийн цалингийн зардлыг төлөвлөж, нийт 5,670.0 мянган төгрөгийг олгосон;
3. Чанарын менежментийн тогтолцооны ISO стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээний үнийн дүнгээс 1,100.0 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн, нягтлан бодох бүртгэлд өглөгийн тооцоог бүртгээгүй, үлдэгдлийг томилолтын зардалд шилжүүлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан;
4. Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 2,500.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал болон урьдчилан төлөвлөх боломжтой шатахууны зардалд 5,400.0 мянган төгрөгийг зарцуулж төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлээгүй.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн бөгөөд аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Стандарттай Архангай” арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газар болон төрийн байгууллагуудад Чанарын удирдлагын тогтолцоо (ISO-9001:2015)-г нэвтрүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд Цэнхэр сумын ЗДТГазар нь 2022 онд Чанарын менежментийн тогтолцооны ISO стандартыг нэвтрүүлж эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Цэнхэр сум орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 850,000.0 мянган төгрөгөөр 1.1 км урттай засмал замыг ЗГБ холдинг ХХК-иар гүйцэтгүүлж, ашиглалтанд хүлээн авч нягтлан бодох бүртгэл, тайланд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 96.5 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	46,021,185.00	52,182,205.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,621,185.00	30,907,205.00
35100	Түүхий эд материал	28,810,600.00	25,624,620.00
35110	Тусгай зориулалттай материал	17,418,920.00	20,094,820.00
35130	Эм боох материал	11,391,680.00	5,529,800.00
35400	Хангамжийн материал	3,810,585.00	5,282,585.00
35410	Бичиг хэргийн материал	869,405.00	1,045,905.00
35420	Аж ахуйн материал	1,661,800.00	3,121,300.00
35430	Сэлбэг хэрэгсэл	11,500.00	7,500.00
35440	Түлш, шатах тослох материал	42,000.00	0.00
35450	Барилгын засварын материал	425,880.00	1,107,880.00
35460	Хүнсний материал	800,000.00	0.00
36	НӨӨЦИЙН БАРАА	13,400,000.00	21,275,000.00
36300	Тэжээлийн нөөц	13,400,000.00	21,275,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,926,469,246.33	2,886,777,366.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,926,469,246.33	2,886,777,366.22
39200	Биет хөрөнгө	1,670,209,246.33	2,630,517,366.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,015,681,516.00	999,794,246.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-232,218,053.44	-258,714,001.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	237,454,800.00	237,454,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-127,464,644.57	-144,685,777.97
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	202,015,363.08	219,365,163.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-109,165,431.96	-123,840,936.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,772,818.00	65,772,818.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-48,822,217.91	-55,599,950.88
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	8,500,000.00	8,500,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,051,667,744.00	1,297,764,958.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-403,112,646.87	-475,193,951.80
39217	Ном	9,900,000.00	9,900,000.00
39300	Биет бус хөрөнгө	256,260,000.00	256,260,000.00
39301	Програм хангамж	650,000.00	650,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	255,610,000.00	255,610,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,972,490,431.33	2,938,959,571.22
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,972,490,431.33	2,938,959,571.22
51	Засгийн газрын хувь оролцоо	1,972,490,431.33	2,938,959,571.22
51100	Засгийн газрын оруулсан капитал	650,717,567.00	650,717,567.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	650,717,567.00	650,717,567.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,050,462,552.83	2,024,663,358.94
51210	Өмнөх үеийн үр дүн	1,023,277,154.45	1,058,194,219.05
51220	Тайлант үеийн үр дүн	27,185,398.38	966,469,139.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	271,310,311.50	263,578,645.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,972,490,431.33	2,938,959,571.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,016,442,205.59	2,093,309,592.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,807,239.59	963,710,280.00
120	Нийтлэг татварын бус орлого	81,807,239.59	963,710,280.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,867,600.00	4,119,784.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,867,600.00	4,119,784.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	76,783,639.59	959,590,496.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,156,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	934,634,966.00	1,129,599,312.00
131009	Хаагдсан данс	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,085,266.00	216,587,712.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,150,000.00	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,435,266.00	203,783,797.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,500,000.00	12,503,915.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	898,549,700.00	913,011,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	898,549,700.00	913,011,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	989,256,807.21	1,117,586,952.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	726,030,407.21	798,786,952.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	628,474,086.85	679,367,997.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,315,900.00	263,841,066.36
210101	Үндсэн цалин	259,315,900.00	215,793,337.49
210102	Нэмэгдэл	0.00	40,755,979.27
210104	Урамшуулал	0.00	7,291,749.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,007,990.64	33,039,500.00
210201	Тэтгэврийн даатгал	23,635,390.64	22,466,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,593,200.00	2,643,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,074,500.00	2,114,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	518,600.00	528,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,186,300.00	5,286,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,200,000.00	25,823,437.70
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	11,523,437.70
210302	Түлш, халаалт	9,200,000.00	14,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,386,383.00	25,694,365.00
210401	Бичиг хэрэг	5,765,400.00	4,997,300.00
210402	Тээвэр, шатахуун	23,969,900.00	10,069,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,223,400.00	2,926,565.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	5,910,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,159,933.00	1,791,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,978,800.00	4,660,000.00
210702	Дотоод албан томилолт	3,978,800.00	4,660,000.00

Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,575,606.00	77,478,567.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,293,566.00	76,980,735.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,900.00	162,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	173,140.00	249,094.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	0.00	31,538.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	214,908,607.21	248,831,061.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,486,180.00	104,945,667.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	152,422,427.21	143,885,394.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,556,320.36	119,418,954.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,625,500.00	57,932,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	21,237,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,625,500.00	36,694,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	62,930,820.36	61,486,654.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,930,820.36	61,486,654.94
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	263,226,400.00	318,800,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	263,226,400.00	318,800,000.00
221001	Их засвар	263,226,400.00	88,800,000.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	30,000,000.00
223001	Бусад хөрөнгө	0.00	200,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	27,185,398.38	975,722,639.25
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	9,253,499.36
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	9,253,499.36
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	27,185,398.38	966,469,139.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	936,502,566.00	1,133,719,096.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,867,600.00	4,119,784.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,867,600.00	4,119,784.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,867,600.00	4,119,784.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,867,600.00	4,119,784.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	934,634,966.00	1,129,599,312.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,085,266.00	216,587,712.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,150,000.00	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,435,266.00	203,783,797.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,500,000.00	12,503,915.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	898,549,700.00	913,011,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	898,549,700.00	913,011,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	571,296,066.00	661,062,578.00

Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	571,296,066.00	661,062,578.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473,739,745.64	541,643,623.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,315,900.00	263,841,066.36
210101	Үндсэн цалин	259,315,900.00	215,793,337.49
210102	Нэмэгдэл	0.00	40,755,979.27
210104	Урамшуулал	0.00	7,291,749.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,769,801.64	33,039,500.00
210201	Тэтгэврийн даатгал	26,397,201.64	22,466,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,593,200.00	2,643,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,074,500.00	2,114,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	518,600.00	528,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,186,300.00	5,286,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,350,000.00	25,823,437.70
210301	Гэрэл, цахилгаан	5,700,000.00	11,523,437.70
210302	Түлш, халаалт	7,650,000.00	14,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,517,278.00	28,528,415.00
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	6,409,400.00
210402	Тээвэр, шатахуун	14,206,000.00	10,069,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,223,400.00	2,926,565.00
210404	Ном, хэвлэл	464,250.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	5,910,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,623,628.00	3,212,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	600,000.00	0.00
210604	Урсгал засвар	600,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	3,978,800.00	4,660,000.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	3,978,800.00	4,660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,025,606.00	93,121,634.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,743,566.00	92,623,802.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,900.00	162,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	173,140.00	249,094.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	0.00	31,538.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,182,360.00	92,629,570.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,182,360.00	92,629,570.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,556,320.36	119,418,954.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,625,500.00	57,932,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	21,237,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,625,500.00	36,694,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	62,930,820.36	61,486,654.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,930,820.36	61,486,654.94

Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	365,206,500.00	472,656,518.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	365,206,500.00	472,656,518.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	365,206,500.00	472,656,518.00
2200	Дотоод эх үүсвэрээр	365,206,500.00	472,656,518.00
220001	Барилга байгууламж	0.00	0.00
221001	Их засвар	263,226,400.00	88,800,000.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	30,000,000.00
223001	Бусад хөрөнгө	0.00	200,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	101,980,100.00	153,856,518.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-365,206,500.00	-472,656,518.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	650,717,567.00	271,310,311.50	1,023,277,154.45	1,945,305,032.95
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	650,717,567.00	271,310,311.50	1,023,277,154.45	1,945,305,032.95
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	27,185,398.38	27,185,398.38
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	650,717,567.00	271,310,311.50	1,050,462,552.83	1,972,490,431.33
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	650,717,567.00	271,310,311.50	1,050,462,552.83	1,972,490,431.33
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	7,731,666.22	7,731,666.22
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	650,717,567.00	271,310,311.50	1,058,194,219.05	1,980,222,097.55
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-7,731,666.22	0.00	-7,731,666.22
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	966,469,139.89	966,469,139.89
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	650,717,567.00	263,578,645.28	2,024,663,358.94	2,938,959,571.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэлийн	Зөрүү	Харьцуулалт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	916,841,600.00	855,644,729.06	61,196,870.94	93.3%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	797,960,000.00	736,844,729.06	61,115,270.94	92.3%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	740,027,700.00	678,912,429.06	61,115,270.94	91.7%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,315,900.00	263,841,066.36	474,833.64	99.8%
210101	Үндсэн цалин	264,315,900.00	215,793,337.49	48,522,562.51	81.6%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,039,500.00	33,039,500.00	0.00	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	22,466,900.00	22,466,900.00	0.00	100.0%

Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	2,643,200.00	2,643,200.00	0.00	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,114,500.00	2,114,500.00	0.00	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	528,600.00	528,600.00	0.00	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	5,286,300.00	5,286,300.00	0.00	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,000,000.00	25,823,437.70	176,562.30	99.3%
210301	Гэрэл, цахилгаан	11,700,000.00	11,523,437.70	176,562.30	98.5%
210302	Түлш, халаалт	14,300,000.00	14,300,000.00	0.00	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	25,608,100.00	25,608,100.00	0.00	100.0%
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	9,098,100.00	9,098,100.00	0.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,400,000.00	0.00	100.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,910,000.00	5,910,000.00	0.00	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,200,000.00	2,200,000.00	0.00	100.0%
2107	Томилолт, зочны зардал	4,660,000.00	4,660,000.00	0.00	100.0%
210702	Дотоод албан томиллолт	4,660,000.00	4,660,000.00	0.00	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	272,534,600.00	219,457,375.00	53,077,225.00	80.5%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	270,584,600.00	218,959,543.00	51,625,057.00	80.9%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	0.00	1,200,000.00	0.0%
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	162,200.00	37,800.00	81.1%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	249,094.00	50,906.00	83.0%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	55,000.00	95,000.00	36.7%
210807	Газрын төлбөр	100,000.00	31,538.00	68,462.00	31.5%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,869,600.00	106,482,950.00	7,386,650.00	93.5%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	113,869,600.00	106,482,950.00	7,386,650.00	93.5%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,932,300.00	57,932,300.00	0.00	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,932,300.00	57,932,300.00	0.00	100.0%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,237,500.00	21,237,500.00	0.00	100.0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,694,800.00	36,694,800.00	0.00	100.0%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	118,881,600.00	118,800,000.00	81,600.00	99.9%
221001	Их засвар	88,881,600.00	88,800,000.00	81,600.00	99.9%
222001	Тоног төхөөрөмж	30,000,000.00	30,000,000.00	0.00	100.0%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	916,841,600.00	855,644,729.06	61,196,870.94	93.3%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	458,897,700.00	851,524,945.06	-	185.6%
320001	Орон нутгийн төсвөөс	458,897,700.00	851,524,945.06	-	185.6%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	457,943,900.00	4,119,784.00	453,824,116.00	0.9%

Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,830,000.00	4,119,784.00	-289,784.00	107.6%
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	454,113,900.00	0.00	454,113,900.00	0.0%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	57.00	53.00	4.00	93.0%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	26.00	2.00	92.9%
620001	Удирдах ажилтан	8.00	8.00	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	13.00	2.00	86.7%
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	0.00	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.00	26.00	2.00	92.9%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00	0.00	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	13.00	2.00	86.7%
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5.00	5.00	0.00	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	216,587,712.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,587,712.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,587,712.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,920,315.00
210401	Бичиг хэрэг	409,400.00
210402	Тээвэр, шатахуун	971,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	526,565.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,012,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,545,217.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,545,217.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,122,180.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,122,180.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	200,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	200,000,000.00
223001	Бусад хөрөнгө	200,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	216,587,712.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	216,587,712.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	203,783,797.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,503,915.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй, харин залруулагдаагүй нийт 21,662.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 840.0 мянган төгрөгт 1 төлбөрийн акт тогтоож, 13,620.0 мянган төгрөгт 2 албан шаардлага, 7,202.8 сая төгрөгт 1 сахилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.2. Чанарын менежментийн тогтолцооны ISO стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээг Тэнүүн сэтгэмж ХХК-тай 13,800.0 мянган төгрөгөөр, баталгаажуулалтын гэрээг Кю сертф ХХК-тай 4,800.0 мянган төгрөгөөр тус тус хийсэн байна. Анхан шатны баримтаас харахад дээрх ХХК-иудтай нийт 18,600.0 мянган төгрөгийн гэрээг байгуулсан бөгөөд гүйлгээний дүнгээс харахад Кю сертф ХХК-д 1,100.0 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн байна. Тэнүүн сэтгэмж ХХК нь 2022 оны 07 сарын 18-22-ны өдрүүдэд Архангай аймгийн Эрдэнэбулган суманд 5 хоногийн сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтын томилолтын тооцоог гэрээнд тусгаагүй, төсвөөс зардлыг гаргасан. Дээрх 5 хоногийн сургалтад Цэнхэр сумын 6 албан хаагч хамрагдсан бөгөөд нийт 1,770.0 мянган төгрөгийн томилолтыг авсан байна. Томилолтын зардлыг бараа үйлчилгээний зардлаас гаргасан бөгөөд Кю сертф ХХК-д дутуу шилжүүлсэн 1,100.0 мянган төгрөгөөс тооцсон гэх боловч анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” Сангийн сайдын 2021 оны 190-р тогтоол, Төрийн хэмнэлтийн хуулийн 15.2.3.Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний дүнгээс хэтэрсэн томилолтын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

3.2 Албан шаардлага

3.2.1. Хог хаягдлыг зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал зардлын дансанд хогийн машины жолоочийн цалинг төлөвлөж, ажил олгогч ажилтнаас олгох НДШ болон ХХОАТ-ыг суутгаж нийт 5,670.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190-р тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын энгийн болон аюултай, овор хэмжээ ихтэй хог хаягдлыг хог, хаягдлын тухай хууль болон холбогдох эрхзүйн актын дагуу устгах, ариутгах, тээвэрлэх, хортон мэрэгчдийн устгал ариутгал, эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг ариутгах, халдваргүйжүүлэхтэй холбоотой гарсан төлбөр хураамжууд энд хамаарна гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.2.2 Засаг даргын нөөц хөрөнгөөс оны шилдэг албан хаагч нарт 1,800.0 мянган төгрөгийн, сумын ачит эхчүүд шагналд 750 мянган төгрөг нийт 2,550.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгосон, урьдчилан төлөвлөх боломжтой 5,400.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2." Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1 " Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" 15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх"; Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.2.3 Сахилгын шийтгэл ногдуулах

ЗДТГ-т хогны машины жолоочоор гэрээтээр ажиллаж байсан албан тушаалтныг тэтгэвэрт гарахад нь 7,202.8 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 3.1.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 82.5, Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна. Дээрх албан тушаалтныг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байсан тул тэтгэмж олгох асуудал хөдөлмөрийн тухай хуулийн 82.1.2-т заасан үндэслэлээр олгогдох байсан гэж үзэн 5,940.0 мянган төгрөгд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн боловч хүлээн зөвшөөрөөгүй тул төсөв захирагчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Шийдвэрлэсэн нь:ЗДТГ-ын даргад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.3.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Элэгдлээ бүрэн нөхсөн 123 нэр төрлийн 228.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд жилийн турш элэгдэл тооцоогүй бөгөөд цаашид ашиглах эсэхийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ., 8.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээ нөхсөн хөрөнгөд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч Өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж одоо ашиглаж байгаа болон цаашид ашиглагдах хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны зааврын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, харин ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг ТБОНӨТХ-ийн 31 дэхь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цэнхэр сумын ЗДТГ	5	21,662.8	1	840.0	2	13,620			1	7202.8		